

Эдийн Засгийн Судалгаа, Эрдэм Шинжилгээний Хүрээлэн



Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалт

**Хөрөнгө оруулалтын орчин,
худалдааны нөхцөлийн харьцуулсан судалгаа**

Улаанбаатар

Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалт

Хөрөнгө оруулалтын орчин, худалдааны нөхцөлийн харьцуулсан судалгаа

**Багийн ахлагч:
Багийн гишүүд:**

**З.Манлайбаатар
Б.Мөнх-Ирээдүй
Б.Дэлгэрмаа
Т.Дөлгөөн**

Улаанбаатар, 2018

АГУУЛГА

УДИРТГАЛ	1
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН	2
ХУДАЛДААНЫ НӨХЦӨЛ	4
ДҮГНЭЛТ	7
НОМ ЗҮЙ	8
ХАВСРАЛТ	9

Зургийн жагсаалт

Зураг 1. Чилийн экспортын бүтээгдэхүүн, 2016 он.....	4
Зураг 2. Монголын экспортын бүтээгдэхүүн, 2016 он.....	5
Зураг 3. Монгол ба Чилийн худалдааны нөхцөл	5
Зураг А 1. Монгол ба Чилийн эдийн засгийг өсөлт, хувиар.....	9
Зураг А 2. Монгол ба Чилид орсон ГШХО, ДНБ-д эзлэх хувиар	9
Зураг А 3. Монгол ба Чилийн Худалдааны эрх чөлөөний индекс (0-100).....	10
Зураг А 4. Монгол ба Чилийн худалдааны нээлттэй байдал, ДНБ-д харьцуулсан %.....	10

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Бизнес эрхлэхүйн болон Авлигын төсөөллийн индекс 2016, 2017 он.....	2
Хүснэгт 2. Монгол ба Чилийн Хөрөнгө оруулалт татах индекс	3
Хүснэгт 3. Монголын худалдааны нөхцөл улирлаар, 2016, 2017 он	6

Товчилсон үгийн жагсаалт

ГШХО	Гадаадын шууд хөрөнгө оруулалт
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
ОУВС	Олон Улсын Валютын Сан
ҮСХ	Үндэсний статистикийн хороо

УДИРТГАЛ

Энэхүү судалгаа нь “Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО)” (ЭЗСЭШХ, 2017) суурь судалгааны үргэлжлэл бөгөөд хөрөнгө оруулалтын орчны үзүүлэлтүүдийг хамгийн сүүлийн үеийн буюу 2017 оны байдлаар шинэчилсэн. Мөн худалдааны нөхцөлийг тооцоолсон нэмэлт бүлэгтэй. Энэ судалгаа Монгол болон Чили улсуудын хөрөнгө оруулалт татдаг нэг гол салбар болох уул уурхайн салбарыг (Banco Santander, S.A., 2018) харьцуулснаараа өмнөх судалгаатай ижил төстэй юм.

“Монгол дахь ГШХО” (ЭЗСЭШХ, 2017) суурь судалгаа нь ГШХО-ын хэлбэлзлийн гол шалтгааныг тодорхойлох, эдийн засаг дахь нөлөөллийг тооцоолох, улс орнуудын сайн туршлагыг нэвтрүүлж, хэрхэн хөрөнгө оруулалтыг татах талаар судлах зорилготой байсан. Уг судалгаанд дурдсанаар, Монгол ГШХО-д шууд нөлөө төдийлөн үзүүлдэггүй бөгөөд ГШХО-ын орох урсгал нь хөрөнгө оруулалтын орчноос илүүтэйгээр түүхий эдийн үнээс хамааралдаг. Гэвч урт хугацаандаа Монгол Улс түүхий эдийн үнийн хэлбэлзлээс хамаарах хамаарлаа бууруулж, хөрөнгө оруулалтын орчноо сайжруулах замаар ГШХО-ыг татахад анхаарах шаардлагатай байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН

2017 онд Хятадын эрэлт нэмэгдсэнтэй холбоотойгоор эрдэс, түүхий эдийн үнэ огцом өсөж, түүнийг дагаад Монгол дахь ГШХО нэмэгдсэн. Түүхий эдийн өндөр үнэ, ОУВС-ийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хэлэлцээр зэрэг нь Монгол Улсын зээлжих зэрэглэлийг өсгөж, цаашлаад хөрөнгө оруулалт татах нөхцөлийг сайжруулжээ. Монгол Улсын зээлжих зэрэглэл бага зэрэг дээшилсэн ч гол бэрхшээлүүд хэвээр байгаа тул гадаадын хөрөнгө оруулагчид ойрын хугацаанд Монголд хөрөнгө оруулах итгэл төдийлөн сайн сэргээгүй байна. Монголтой адил байгалийн нөөц ихтэй Чили улсын жишээнээс ГШХО татахын тулд юу хийх ёстойг харж болно. Гэвч хөрөнгө оруулалт орж ирэхэд саад болж буй бэрхшээлүүд Монгол болон Чили улсын хувьд ялгаатай юм.

АНУ-ын Төрийн департаментын дүгнэснээр, Латин Америкт байрладаг Чили Улс хөрөнгө оруулагчдын хамгийн ихээр анхаарал хандуулдаг орнуудын нэг. Учир нь Чили бол чөлөөт эдийн засагтай, институцийн хөгжил болон хууль дээдлэх хандлага сайн улс. Гэхдээ сүүлийн жилүүдэд Чилийн хөрөнгө оруулалтын орчны талаарх төсөөлөл муудсан. Ойлгомжгүй, урьдчилан таамаглаагүй, улс төрийн нөлөөтэй байж болох хүчин зүйлсээс шалтгаалан том хөрөнгө оруулагчдын зөвшөөрөл авах үйл явц удааширч, зардал нэмэгджээ. Орон нутгийн иргэд шүүхэд хандах замаар томоохон хөрөнгө оруулалтын төслүүдийг саатуулах болсон бөгөөд уг эрх зүйн маргааныг шийдвэрлэхэд ихээхэн хугацаа шаардагдах болжээ.

Дэлхийн банкны “Бизнес эрхлэхүй” тайланд дурдсанаар, Монгол Улсад бизнес эрхлэхэд тулгарч буй хамгийн бэрхшээлтэй 5 зүйл бол гадаад валютын зохицуулалт, авлига, улс төрийн тогтворгүй байдал, засгийн газрын хүнд суртал, засгийн газрын тогтворгүй байдал юм.

Хүснэгт 1. Бизнес эрхлэхүйн болон Авлигын төсөөллийн индекс 2016, 2017 он

		Монгол		Чили	
		2017	2016	2017	2016
Бизнес эрхлэхүйн индекс (DBI)	оноо	69.0	68.2	71.2	69.6
	байр	62/190	64/190	55/190	57/190
Авлигын төсөөллийн индекс (CPI)	оноо	36	38	67	66
	байр	103/180	87/176	26/180	24/176

Эх сурвалж: Transparency International, Doing Business

Дэлхийн эдийн засгийн форумын Гүйцэтгэх захирлуудын санаа бодлын судалгаанд (2017) тодорхойлсноор, авлига нь бизнес эрхлэхэд тулгарах гол саад ажээ. 2017 онд Монгол Улсын Авлигын төсөөллийн индекс (CPI) 2016 онтой харьцуулахад 2 нэгжээр буурч сайжирсан. Гэвч бусад улсын индекс илүү сайжирсан тул Монгол Улс 87-р байрнаас 103-р байр руу ухрав. Чилийн Авлигын төсөөллийн индекс болон эрэмбэ нь Монгол Улсаас нэлээд дээгүүр байна. Ер нь Чилид авлигын түвшин ихэнх Латин Америкийн орнуудтай харьцуулахад бага байдаг.

Монгол болон Чили улсад хоёуланд нь тулгардаг нийтлэг бэрхшээл бол улс төрийн тогтворгүй байдал ба засгийн газрын хүнд суртал юм. Эдгээр асуудал нь ГШХО-ын орох урсгал саарахад ихээхэн нөлөө үзүүлдэг.

Бизнес эрхлэхүйн индекс (DBI) болон Авлигын төсөөллийн индекс нь тухайн улсын бизнесийн орчны талаар ерөнхий ойлголт өгөх үзүүлэлт юм. Гэвч эдгээр үзүүлэлт Чили болон Монголын ГШХО-ыг татагч гол хүчин зүйл болох уул уурхайн салбарын талаар мэдээлэл өгдөггүй. Иймээс илүү сайн төсөөлөл авахын тулд байгалийн баялаг ихтэй орны бизнесийн орчныг тодорхойлдог үзүүлэлтийг харах шаардлагатай.

“Монгол Улс дахь ГШХО” суурь судалгаанд ашигласан Хөрөнгө оруулалт татах индекс (IAI) нь Бодлогын төсөөллийн индекс (PPI) болон Ашигт малтмалын боломжийн индекс (MPI) гэсэн хоёр индексээр тодорхойлогддог. Доорх хүснэгтэд эдгээр үзүүлэлтийн Монгол болон Чили улсын оноо, эрэмбийг харууллаа.

Хүснэгт 2. Монгол ба Чилийн Хөрөнгө оруулалт татах индекс

	Монгол		Чили	
	2016	2017	2016	2017
Хөрөнгө оруулалт татах индекс (IAI)	49.4	60.7	69.7	81.5
	81/104	53/91	39/104	8/91
Бодлогын төсөөллийн индекс (PPI)	28.1	54.2	78.7	80.6
	101/104	70/91	35/104	25/91
Ашигт малтмалын боломжийн индекс (MPI)	63.6	65.0	63.6	82.1
	50/104	36/91	49/104	7/91

Эх сурвалж : Fraser Institute

2016, 2017 онд Монгол болон Чили улсын Хөрөнгө оруулалт татах индекс ихээхэн нэмэгджээ. Хөрөнгө оруулалт татах индексийн 40 хувийг бодлогын ойлголт, үлдсэн 60 хувийг ашигт малтмалын боломжийн индекс тодорхойлдог.

Дээрх хугацаанд Монгол Улсын Бодлогын төсөөллийн индекс 101-р байраас 70-р байрт дэвшсэн ба оноо нь 20 гаруй нэгжээр нэмэгджээ. Энэхүү өсөлт нь геологийн мэдээллийн сангийн тодорхой бус байдал 39 нэгжээр буурсан, хөдөлмөрийн чадвар ажиллах хүчний олдцын талаарх болгоомжлол 32 нэгжээр буурсан, хамгаалалттай газрын тодорхой бус байдал 27 нэгжээр буурсан зэргээс шалтгаалжээ. Ашигт малтмалын боломжийн индекс багахан нэмэгдсэн боловч Бодлогын төсөөллийн индекс ийнхүү эрс өссөнөөр Монголын Хөрөнгө оруулалт татах индексийн эрэмбэ 81-р байрнаас 53-р байрт дэвшжээ.

Харин Чили Улсын Хөрөнгө оруулалт татах индекс огцом сайжирч, хөрөнгө оруулалт татах чадвараараа хамгийн сайн 10 улсын нэг болсон. Энэхүү өсөлтөд Ашигт малтмалын боломжийн индекс 49-р байраас 7-р байрт хүрч, оноо нь 20 нэгжээр нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлэв. Гэхдээ Чилийн Бодлогын төсөөллийн индекс бас өсжээ. Үүнд Чилийн хуулийн системд эргэлзэх эргэлзээ 16 нэгжээр буурсан, татварын тогтолцооны тодорхой бус байдал 14 нэгжээр буурсан, геологийн мэдээллийн сангийн тодорхой бус байдал 16 нэгжээр буурсан нь тус тус нөлөөлжээ.

Чили улс Монголтой төстэй боловч худалдааны нөхцөлийн хувьд Монголын оноо, эзлэх байр Чилийнхээс нэлээд доогуур байгаа юм. Хэрэв Чилийн сайн туршлагыг нэвтрүүлж чадвал Монгол нь байгалийн баялаг ихтэй, гадаадын хөрөнгө оруулалтыг татагч нэг чухал улс болох боломжтой юм.


ХУДАЛДААНЫ НӨХЦӨЛ

Худалдааны нөхцөл (terms of trade) нь тухайн улсын экспорт, импортын үнийн харьцаагаар тодорхойлогддог (Investopedia, 2018). Global Economy and Trading Economics зэрэг олон улсын байгууллагууд улс орнуудын худалдааны нөхцөлийг тооцохдоо 2000 оныг суурь оноор авч, Нэгдсэн Үндэсний Байгууллага, Дэлхийн Банкны тоон мэдээллийг ашигладаг. Харин ОУВС улс орнуудын Худалдааны нөхцөлийг экспорт, импортын үнийн индексийн харьцаагаар илүү хялбараар тооцоолох аргыг боловсруулсан байдаг (IMF, 2009).

Хэдийгээр үнийн харьцааны тооцоолол энгийн боловч, эдийн засагчдын анхаарлыг татдаг асуудал бол худалдааны нөхцөлийн өөрчлөлт эдийн засгийн бодит орлогод хэрхэн нөлөөлдөг тухай юм. Худалдааны нөхцөл өссөн гэдэг нь экспортын үнэ өртөг импортын үнэ өртгөөс ихээр нэмэгдсэнийг илэрхийлдэг. Тухайн улс экспортын орлогоороо илүү их хэмжээний импортын бараа бүтээгдэхүүн худалдан авч чадна гэсэн үг. Жишээлбэл, газрын тосны үнийн өсөлт газрын тос экспортлогч улсын худалдааны нөхцөлийг сайжруулж, бусад улсынхыг бууруулна.


“Монгол Улс дахь ГШХО” (ЭЗСЭШХ, 2017) суурь судалгааны тайланд дурдсанаар, Чили бол ижил төрлийн экспортын бүтэцтэй орнуудтай харьцуулахад эдийн засгийн хувьд харьцангуй таатай улс юм. Доорх зурагт Чили ба Монголын экспортын бүтээгдэхүүнийг харуулав. Чилийн экспортын 50 орчим хувийг нь эрдэст бүтээгдэхүүний экспорт бүрдүүлдэг. Харин Монголын хувьд эрдэст бүтээгдэхүүний экспорт нийт экспортын 70 орчим хувийг бүрдүүлж байна. Хоёр улсын хоорондох гол ялгаа бол Чили Улс зэсийн хүдэр олборлож, дотооддоо боловсруулан экспортолдог бол Монгол Улсын цэвэршүүлсэн зэсийн экспорт нийт экспортын ердөө 1 орчим хувийг эзэлдэг.

Зураг 1. Чилийн экспортын бүтээгдэхүүн, 2016 он



Эх сурвалж: Observatory of Economic Complexity

Зураг 2. Монголын экспортын бүтээгдэхүүн, 2016 он




Эх сурвалж: Observatory of Economic Complexity

Улс орон бүрийн эдийн засгийн нөхцөл байдал харилцан адилгүй учраас Монгол Улстай харьцуулахад яг тохирох улс нэрлэхэд бэрхшээлтэй. Гэсэн хэдий ч 1970 онд Чили Улсын экспортын 84 орчим хувийг уул уурхайн салбар бүрдүүлж байснаа 2016 оны байдлаар 50 хувь болж буурсан нь Монголын хувьд загвар болгож болохуйц байна. Чили улс түүхий эд экспортлогчоос боловсруулагч, цэвэршүүлэгч болж өөрчлөгдсөн ба 2016 оны байдлаар экспортынх нь 20 орчим хувийг цэвэршүүлсэн зэс бүрдүүлж байна.

Худалдааны нөхцөлийг тооцоходоо 2000 оныг суурь оноор авч, ОУВС-ийн аргачлалыг ашиглалаа (2000=100). Доорх графикт 2000-2017 оны Монгол, Чили улсуудын худалдааны нөхцөлийг харуулав. Тооцооллын үр дүнгээс харахад, Монгол ба Чилийн худалдааны нөхцөлийн өөрчлөлт төстэй байна. Гэвч 2012 оноос эхлэн хоёр улсын үзүүлэлтийн зөрүү нэмэгдэж эхэлжээ. 2012 оноос хойш Монголын худалдааны нөхцөл Чилийнхээс дунджаар 13 хувиар бага байв. Харин 2017 онд Монголын зэс болон нүүрсний экспорт нэмэгдсэнтэй холбоотойгоор Чилийн үзүүлэлтээс давжээ.

Зураг 3. Монгол ба Чилийн худалдааны нөхцөл



Эх сурвалж: TheGlobalEconomy.com, НҮБ, Судалгааны багийн тооцоолол

2000-2017 онд Монголын худалдааны нөхцөлийн дундаж үнэлгээ 145.3, хамгийн бага утга 50, хамгийн их утга 238.3 байжээ. 2011 он хүртэл индекс алгуур өсөж байсан бол түүнээс хойш түүхий эдийн экспортын өндөр орлого, эдийн засгийн хурдтай хөгжлийн дүнд худалдааны нөхцөлийн утга 227.6 болж нэмэгдсэн. Гэвч үзүүлэлт саарч эхэлсэн. Монголбанкны дүгнэснээр, 2015 онд худалдааны нөхцөл буурсан нь зэсийн баяжмал, төмрийн хүдэр, нефтийн экспортын үнэ буурсантай холбоотой байв (Монголбанк, 2016). 2016 онд худалдааны нөхцөл түүхий эдийн үнийн бууралтаас шалтгаалан өмнөх онтой харьцуулахад 7 хувиар буурчээ.

Хүснэгт 3. Монголын худалдааны нөхцөл улирлаар, 2016, 2017 он

	2016				2017		
	I	II	III	IV	I	II	III
Экспортын үнийн индекс	251	245	340	369	478	477	402
Импортын үнийн индекс	187	188	186	184	185	181	186
Худалдааны нөхцөл	134	131	183	200	259	263	216

Эх сурвалж:ҮСХ, Судалгааны багийн тооцоолол

Харин Монголын худалдааны нөхцөл уул уурхайн салбарын нөлөөгөөр 2017 оны эхний хоёр улиралд өсөж, хамгийн өндөр түвшинд хүрчээ. Засгийн газар нийт орлогынхоо 20 хувьтай тэнцэх хэмжээний татварыг экспортын гол түүхий эд болох нүүрс, зэс, алт, төмрийн хүдрийн орлогоос цуглуулжээ. 2017 онд нүүрс болон зэсийн экспортын орлого нийт уул уурхайн орлогын 88.3 хувийг бүрдүүлсэн ба нүүрсний экспорт түүхэн дэх хамгийн өндөр түвшиндээ хүрэв.

Хэдийгээр Монголын эдийн засгийн өсөлт, ГШХО-ын орох урсгалын ДНБ-д эзлэх хувь зэрэг макро үзүүлэлт Чилийнхээс өндөр байдаг ч худалдааны чөлөөт байдалтай холбоотой зарим үзүүлэлт тааруу байна (тоон мэдээллийг Хавсралт хэсгээс харна уу). Мөн Монголын худалдааны нээлттэй байдал¹ (trade openness index) Чилийнхээс хоёр дахин өндөр байдаг боловч худалдааны эрх чөлөөний индекс² (trade freedom index) сүүлийн арван жилийн турш Чилийнхээс харьцангуй доогуур байгаа юм. Түүнчлэн уг үзүүлэлт 2014 оноос хойш эрс буурч эхэлсэн. Энэ нь Монголын зохицуулалтын орчин, гааль ба хөрөнгө оруулалтын хязгаарлалт, төрийн шууд оролцоо зэргээс шалтгаалан өрсөлдөх чадвар суларсантай холбоотой.

¹ Экспорт, импортын нийлбэрийг ДНБ-д харьцуулж тооцдог

² Худалдааны эрх чөлөөний индекс нь хоёр хүчин зүйлээс хамаардаг: дундаж тариф болон тарифын бус саад бэрхшээл (тоо хэмжээ, үнэ, зохицуулалт, гааль болон хөрөнгө оруулалтын хязгаарлагдмал байдал, засгийн газрын шууд оролцоо гм.)

ДҮГНЭЛТ

2017 онд Монголын эдийн засаг өмнө нь байгаагүй их хэмжээний эрдэс түүхий эдийг экспортолсон. Энэ нь БНХАУ-ын засгийн газраас агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээ авч дотоодын олборлолтыг бууруулсны улмаас импортын эрэлт нэмэгдэж, үнэ өссөнтэй холбоотой.

“Монгол Улс дахь ГШХО” (ЭЗСЭШХ, 2017) суурь судалгаанд дурдсанаар, ГШХО-ын өсөлт эрдэст бүтээгдэхүүний үнэ өсөж үйлдвэрлэл нэмэгдсэнтэй холбоотой байдаг. Иймээс Монгол дахь ГШХО өсөх төлөвтэй байгаа бөгөөд Монголын зарим индекс бас өссөн.

2017 онд 2016 онтой харьцуулахад Монголын зарим үзүүлэлт өссөн боловч гол бэрхшээлүүд хэвээр байгаа тул гадаадын хөрөнгө оруулагчид Монголд хөрөнгө оруулалт хийхдээ итгэлтэй биш хэвээр байна. Гадаадын хөрөнгө оруулагчид Монголын Засгийн газраас бизнес эрхлэх орчин бүрдүүлэх, сайжруулах чиглэлээр тууштай алхам хэрэгжүүлэх, бизнесийн тухай бодлого боловсруулж, хэрэгжүүлэхдээ илүү ил тод, оролцоог хангасан, үр дүнтэй байдлаар хандахыг сануулсаар байна.

Монголын худалдааны нөхцөл сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байна. Годруулбал, 2011 оноос хойш Монголын худалдааны нөхцөл буурч байсан ч 2014 онд экспортын 44 хувийг зэсийн экспорт бүрдүүлснээр өсөж эхэлсэн. 2017 онд тус үзүүлэлт урьд өмнө нь байгаагүй өндөр түвшинд хүрч, Чилийн үзүүлэлтийг давжээ. Энэ нь Монголын зэс, нүүрсний экспортын үнэ нэмэгдсэнтэй холбоотой. Гэхдээ энд Монгол ба Чилийн экспортын бүтээгдэхүүний бүтэц ялгаатай байгааг тэмдэглэх нь зүйтэй юм.

Монголын макро эдийн засгийн зарим үзүүлэлт Чилийнхээс өндөр байгаа боловч институцийн болон хөрөнгө оруулалтын орчин муу хэвээр байна. Сүүлийн жилүүдэд Монголын ГШХО-ын орох урсгалын ДНБ-д эзлэх хувь Чилийнхээс харьцангуй доогуур байгаа нь авлигын түвшин ихтэй, улс төрийн байдал тогтворгүй байдагтай холбоотой. Чилийн ДНБ-ий хэмжээ Монгол Улсынхаас 22 дахин их байдгийг харгалзвал Монголд орох ГШХО хэтэрхий чамлалттай байна.

НОМ ЗҮЙ

Banco Santander, S.A. (2018, March). *Chile: Foreign Investment*. Retrieved from Santander TradePortal: <https://en.portal.santandertrade.com/establish-overseas/chile/foreign-investment>

IMF. (2009). *Export and Import Price Index Manual*. Washington D.C: International Monetary Fund.

Investopedia. (2018, February). *Terms of Trade - TOT*. Retrieved from Investopedia: <https://www.investopedia.com/terms/t/terms-of-trade.asp>


Монголбанк. (2016). Гадаад худалдааны тойм. Улаанбаатар: The Bank of Mongolia. Retrieved from <https://www.mongolbank.mn/documents/statistic/externalsector/tradebalancereview/2015/10e.pdf>

ЭЗСЭШХ. (2017). *Монгол улс дахь ГШХО*.

ЭЗСЭШХ. (2018). *Монгол улс дахь ГШХО- Хөрөнгө оруулалтын орчин, худалдааны нөхцөлийн харьцуулсан судалгаа*.


ХАВСРАЛТ

Зураг А 1. Монгол ба Чилийн эдийн засгийг өсөлт, хувиар




Эх сурвалж: TheGlobalEconomy.com, The World Bank, The Heritage Foundation

Зураг А 2. Монгол ба Чилид орсон ГШХО, ДНБ-д эзлэх хувиар




Эх сурвалж: TheGlobalEconomy.com, The World Bank, The Heritage Foundation

Зураг А 3. Монгол ба Чилийн Худалдааны эрх чөлөөний индекс (0-100)



Эх сурвалж: TheGlobalEconomy.com, The World Bank, The Heritage Foundation

Зураг А 4. Монгол ба Чилийн худалдааны нээлттэй байдал, ДНБ-д харьцуулсан %



Эх сурвалж: TheGlobalEconomy.com, The World Bank, The Heritage Foundation